## "БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ
## 2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 11 дүгээр сарын 30 Багануур дүүрэг

| № | ҮНДЭСЛЭЛ | ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|---|---|---|---|
| 1. | БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл | - Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, МУЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1.11.3, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 дахь заалтын хүрээнд Мон-Энержи Консалт ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийн ажлын зураг боловсруулах явцад зургийн даалгаврын дагуу хяналт тавьж зарим хангалтгүй гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авч байна.<br>- Паркийн цахилгаан хангамжийн зураг төсөл ЭХЯ-ны эрчим хүчний хөгжлийн төвийн магадлалаар хянагдаж бүрэн дууссан.<br>- Цахилгаан хангамжийн зураг төслийн асуудлаар гүйцэтгэгч байгууллага Мон-Энержи Консалт ХХК болон Багануур дүүргийн Газар зохион байгуулалтын албаны холбогдох мэргэжилтэнтэй үндсэн 110/35/10 дэд станцаас Хүнсний үйлдвэрлэлийн бүсийг тэжээх 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын трассыг зөвшилцөж баталгаажуулсан.<br>- Мон-Энержи Консалт ХХК-ийн гүйцэтгэж байгаа БҮТП-ийн цахилгаан хангамжийн зураг төслийг актаар 2021.12.01-ний өдөр Барилгын хөгжлийн төвд хүлээлцэж авахаар товлож байна. | 100% |
| 2. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2.3 | - Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Д.Ихбаяр, Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын орлогч дарга Б.Энхсүрэн, Нийслэлийн Хөгжлийн корпорацийн захирал Энхтайван нартай 2021 оны 11 дүгээр сарын 9-нд уулзалт зохион байгуулж: Үйлдвэрлэл технологийн паркуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хамтын ажиллагааг бий болгох, ҮТП-ийн хуулийн шинэчилсэн найруулгад оруулах саналуудыг нэгтгэн хэлэлцэх, 2022 оны Нийслэлийн төсөвт Паркийн эрчим хүчний хөрөнгө оруулалтын саналуудыг дэмжүүлэх зэрэг асуудлуудыг танилцуулан зөвшилцөв.<br>- 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркад зохион байгуулагдсан "Үйлдвэрлэл, технологийн паркуудын тулгамдсан асуудал" хэлэлцүүлэг уулзалтад БҮТП-ийн удирдлага, Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн нар оролцож паркийн тулгамдсан асуудал болон хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ж.Сандагсүрэн, Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Д.Ихбаяр даргатай уулзан тодорхой асуудлуудыг хэлэлцэв. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | - НЗД-ын 1 дүгээр орлогч Сандагсүрэн дарга Багануур дүүрэгт ажиллах үеэр НӨУАГ-ын дарга болон хэлтсийн дарга нарт БҮТП-ийн албан конторын хуучин барилга болон шинэ баригдах "Захиргаа нэгдсэн үйлчилгээний төв"-ийн газрыг биечлэн үзүүлж, нөхцөл байдлыг танилцуулсан. Тус газраас хуучин барилгын асуудлаар НЗД-ын УЗ-ийн хуралд танилцуулга хийхээр холбогдох материалуудыг хүлээн авсан. | |
| 3. | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга | УИХ-ын Үйлдвэржилтийн байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэгт Газрын дарга орж ажилласан. Ажлын хэсэг "Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан ҮБХ-д хүргүүлсэн. | 100% |
| 4. | Байгууллагын дотоод үйл ажиллагаа | - Байгууллагын Даргын зөвлөлийн хурлаар дотоод үйл ажиллагаа, цаг үеийн асуудлыг тогтмол хэлэлцэж шийдвэрийг гаргаж байна.<br>- Байгууллагын Дотоод хяналт, шалгалтын комисс байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын цаг ашиглалт, ажил үүргийн гүйцэтгэлд хяналт тавьж, улирал тутам хяналт шалгалтыг зохион байгуулж даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажиллаж байна.<br>- Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, цаг үетэй холбогдон гарсан ЗГ-ын тогтоол, НЗД-ын захирамжийн хэрэгжилтийг чанартай зохион байгуулан мэдээ, тайланг заасан хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| 5. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.4 | - Авилгатай тэмцэх газраас төрийн байгууллагын албан хаагч нарт авилгын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, барилгаас нийгэмд учруулах хор аюулыг ухуулан сурталчлах цахим сургалтыг 11 болон 12 дугаар саруудад зохион байгуулахтай холбогдуулан хамруулах албан хаагчдын мэдээллийг гарган batorgil.t@ulaanbaatar.mn цахим хаягаар хүргүүлсэн.<br>- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв иргэдийн хэрэглээний боловсролын төвтэй хамтран төрийн албан хаагчдын дунд 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсан "Амьдралын зөв дадал хэвшил" сургалтанд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан 2 албан хаагчийг хамруулсан.<br>- Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга сургалтанд Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн оролцов.<br>- Төрийн албаны Зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн цахим системийг ашиглах нь" сургалтад Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн цахимаар оролцсон.<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Сургалт, судалгааны төвийн үндсэн болон сэдэвчилсэн, Удирдлагын академитай хамтран зохион байгуулах чиглүүлэх богино хугацааны багц сургалтад | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2022 онд хамрагдах албан хаагчдын сургалтын хэрэгцээ тодорхойлох цахим судалгаанд албан хаагчдыг бүрэн хамруулсан.<br>- Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлөөс 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, анхаарах асуудал" сэдэвт цахим сургалтад Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн хамрагдсан.<br>- Дүүргийн ЗДТГ-аас 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжид орсон өөрчлөлт, түүний хэрэгжилт" сургалтад Нягтлан бодогч хамрагдсан. | |
| 6. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж | - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- 2021 оны 11 дүгээр сарын байдлаар хариутай 9, хариугүй 12 нийт 21 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 0.67<br>- 2021 оны 11 дүгээр сарын байдлаар "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 13 албан бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100%<br>- 11 дүгээр сард ээлжийн амралт авсан 2 албан хаагчийн мэдээллийг ERP системд оруулж амралтыг бүртгэлжүүлсэн. | 100% |
| 7. | ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол | - 2021 оны 11 дүгээр сарын байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 5, цар тахалтай холбоотой 20, цаг үеийн шинж чанартай 45 мэдээллийг байршуулсан.<br>- Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.2, Багануур дүүргийн Засаг даргын 2021 оны А/161 дүгээр захирамжийн 4 дэх заалтуудын дагуу батлагдсан "Хотын соёл" аяныг зохион байгуулах удирдамжийн хүрээнд тусгай төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа тайланг сар бүрийн 20-нд дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэст, 25-нд НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Соён гэгээрүүлэх тасагт тайлагнан ажиллаж байна. | 100% |
| 8. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль | - www.shilendans.mn сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна.<br>- Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох мэдээ тайланг хугацаанд нь гарган хүргүүлж байна.<br>- Нийслэлийн өмч ашиглалт, удирдлагын газарт байгууллагын санхүүгийн тайланг, танилцуулгын хамт цахимаар хүргүүлсэн.<br>- ААНБ-ын 2021 оны улсын тооллогод хамрагдаж, ERP системийн "Үйл явдал" цэсэнд тавигдсан тооллогод тоологдсон давалгаанд тоологдсон гэрчилгээг хавсаргасан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 9. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.1 | - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна.<br>- 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвар бүртгэгдсэн эсэх судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж, 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд мэдээг шинэчлэн НЗДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP чатад хүргүүлэн ажилласан. 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвар бүртгэгдсэн тохиолдолд мэдээг хүргүүлэхээр болсон.<br>- Нийслэлийн Онцгой комиссын 2021.10.15-ны өдрийн 668 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Дельта хувилбарын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан 10 дугаар сарын 18-ны өдрийн даргын зөвлөлийн хурлаар түрээслүүлэгч байгууллагад коронавирусын халдвар ихсэж, ажилтнууд халдвар авах эрсдэл өндөр гэж үзэн 0-12 насны хүүхэдтэй, гэрээсээ ажиллах хүсэлтэй албан хаагчдыг цахимаар ажиллуулахаар шийдвэрлэж, 4 албан хаагчийг цахимаар ажиллуулж байна.<br>- НОК-ын Шуурхай штабын 2021.11.15-ны өдрийн 18 дугаар хурлын тэмдэглэл, 11.16-ны өдрийн 717 дугаартай албан бичиг, Багануур дүүргийн Онцгой комиссын 2021.11.19-ний өдрийн 367, 11.22-ны өдрийн 371 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу албан хаагчдыг ковид-19 халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунд хамруулах арга хэмжээг авч мэдээг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.<br>- Мөн Багануур дүүргийн Онцгой комиссын 2021.11.22-ны өдрийн 371 дугаартай албан бичгийн хүрээнд 11.23-ны өдөр зохион байгуулсан, Монголын дархлаа, бичил амь судлалын нийгэмлэг АУ-ны доктор, дэд профессор С.Чимэдцэрэний хүргэсэн “Вакцины нэмэлт тунтай холбоотой шинжлэх ухаанд суурилсан зөвлөмж мэдээллүүд”-ийг албан хаагчдад өгсөн.<br>- НОК-ын 2021.11.24-ний өдрийн 723 дугаартай албан бичгээр өгсөн “Коронавируст халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө”-ний 1.1, 1.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- Ажилтнуудыг 3 дугаар тунд хамруулах ажлын хүрээнд хамрагдвал зохих нийт 10 ажилтнаас 3 ажилтан хамрагдаад байна.<br>- Спутник вакцин тариулсан 2 ажилтанд 3 дугаар тунд ямар вакцин сонгох, үр дүнг яаж харгалзах тухайд Эрүүл мэндийн төвөөс тодорхой зөвлөмж ирүүлэхгүй байгаа тул тухайн иргэд хүлээзнэж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | - Үлдсэн ажилчид 9-10 дугаар сард ковид халдвараар хүндэвтэр өвчилж, одоогоор сэргээн засах эмчилгээ хийгдэж байгаа бөгөөд эмчийн зөвлөмжөөр 3-р тунд хамрагдана. | |
| НЭМЭЛТ АЖИЛ | | | |
| 10. | НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. | | 100% |
| 11. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна. | | 100% |
| 12. | Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн судалгааг шинэчлэн гаргаж байгаатай холбогдуулан байгууллагын Спорт, эрүүл мэндийн салбар зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 173 дугаартай албан бичгээр дүүргийн ЭМТ-д хүргүүлсэн. | | 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХЗАЯА